



# **Хүүхдийн амьдралын эхний жилүүдэд үзүүлэх хэл заслын эрт үеийн дэмжлэг тусламж**

*Проф. Приходько Оксана Георгиевна  
Москва хотын багшийн их сургуулийн  
тусгай хэрэгцээт боловсрол, сэтгэл судлалын институтын  
захирал, сурган хүмүүжүүлэх ухааны доктор*

# Хүүхдийн хэл яриа


- Хүүхдийг амжилттай нийгэмшүүлэх чухал бүрэлдэхүүн хэсгийн нэг нь хэл яриа бөгөөд хүүхдийн хөгжлийн эрт үе буюу 1-3 насанд маш эрчимтэй хөгждөг.
- Хүүхдэд хэл яриа бий болсноор түүний сэтгэцийн үйл ажиллагаа бүхэлдээ хөгжиж эхэлдэг. Танин мэдэхүй, сэтгэлийн хөдөлгөөний хүрээний хүрээнд ихээхэн өөрчлөлт гарна. Хэл яриа нь хүүхэд зан үйлээ удирдах, сэтгэлийн хөдөлгөөний хөгжил, уураг тархины бүтэц, бүрэлдэхүүн хэсэг, түүний үйл ажиллагаанд чухал нөлөө үзүүлнэ.
- Хэл яриа нь хүүхдийн эх хэлээ амжилттай эсвэл (амжилтгүй) эзэмшиж буй байдлыг илтгэдэг бөгөөд түүний 1 ээс -3 хүртэл насанд олж авч байгаа нийгэмшлийн гол ололт болж өгдөг.

- 
- Балчир насны хүүхдэд хэл яриа үүсч бий болж байгаа нь тухайн насны хүүхдийн **харилцаа - танин мэдэхүйн идэвхтэй байдал**- ыг нь илтгэн харуулж өгдөг.
  - Энэхүү идэвхтэй байдлын гол үндэс нь хүүхдийн ирээдүйн сэтгэцийн дээд үйл болох сэтгэхүй, хэл яриа, анхаарал, ой тогтоолтын хөгжилд нөлөөлдөг.
  - Иймээс балчир насны хүүхдэд үзүүлэх эрт үеийн засан сайжруулах ажлын гол үндэс нь хүүхдийн энэхүү харилцаа танин мэдэхүйн идэвхтэй байдлыг өдөөж сэдэлжүүлэх, түүнийг төлөвшүүлэх ажил юм.



□ Харамсалтай нь хүүхдийн хэл яриаг бага насанд нь зорилго чиглэлтэй хөгжүүлэх ажил өргөн хүрээнд практикт нэвтрээгүй. Өнөөг хүртэл багш нар түүний араас эцэг эхчүүд хэвшмэл буруу ойлголттой, *жишээлбэл 5 наснаас өмнө хэл засалч багшид үзүүлэх шаардлага байна уу? хүүхэд маань 2 нас хүрсэн ч дуугүй байна, харин үе тэнгийнхэн нь дэлгэрэнгүй өгүүлбэрээр чөлөөтэй ярьж байна, үүнд санаа зовох хэрэг байна уу? Эрэгтэй хүүхэд эмэгтэй хүүхдээс хожуу хэлд ордог, 5 нас хүртэл нь байдлыг жаахан харъя, аяндаа хэлд орох байх г. м.* Гэвч ихэнх тохиолдолд өнгөрсөн хугацаанд засрах боломжгүй болсон, үнэт цаг хугацаагаа алдсан байдаг.


□ Иймээс эцэг эхчүүд хүүхдийн хэл ярианд идэвхгүй хандаж болохгүй, ихэнх хүүхэд 3 наснаас хойш ярьж эхэлдэг гэх мэтээр санаа амарч болохгүй.


- 
- Оросын эрдэмтэд маш ойлгомжтойгоор хүүхдийг хэл ярианы хөгжилд насанд хүрэгчид эцэг эх тусгай боловсролын багш нарын өдөөх идэвхжүүлэх үйл ажиллагаа маш чухал, насны ялгаа байгүй гэдгийг тогтоосон. Балчир, бага насанд Хүүхдэд насанд хүрэгчдийн зүгээс үзүүлэх сэдэлжүүлэх ажлын хангалтгүй байдал нь хүүхдийн сэтгэцийн тэр дундаа хэл яриа хөгжих төлөвших тэрхүү чухал үндэс сууринд эргэлт буцалтгүй сөрөг нөлөө үзүүлэх байдалд гарцаагүй хүргэдэг.
  - Бага насны хүүхдийн хэл яриаг хөгжүүлэх мэргэжилтэнд тусгай шаардлага тавигддаг. Хэл заслын эрт үеийн дэмжлэг тусламж үзүүлэх мэргэжилтнүүдийн зайлшгүй эзэмшсэн байх нөхцлийн нэг нь хүүхдийн бие бялдар, оюун ухаан, хэл ярианы хөгжлийн зүй тогтол, хэл заслын эрт үеийн цогц оношилгооны арга, хэл заслын ажлын технологийн талаар мэдлэгтэй байх явдал юм.
  - хүүхдийн бие бялдар сэтгэцийн хөгжлийн талаарх мэдлэг, эрт үеийн дэмжлэг тусламж засан сйажруулах ажил, түүнийг зохион байгуулах технологи, энэ бүгд болон бусад олон хүчин зүйлсээс түүний мэргэжлийн ур чадвар нэр хүндийг илэрхийлнэ.

## Нялх балчир насны хүүхдийн харилцаа танин мэдэхүй идэвхтэй байдлын хөгжлийн зүй тогтол


- Орчин үеийн хэл заслын ш/ ухаан нь хүүхдийн хөгжлийн эхний жил болон балчир насанд үүсч буй хэл ярианы хөгжлийн асуудалд ихээхэн анхаарал хандуулах болсон.
- Хэл заслын ш/ухаан нь хэл яриа нь сэтгэцийн дээд үйл ажиллагааны нэгэн адил харилцааны явцад үүсч, хөгжиж, хэрэгждэг гэдгийг тогтоосон. Хэл яриаг үүсч бий болоход бэлдэж хөгжүүлэх хэрэгтэй. Хэл ярианы хэвийн хөгжилд биологийн хөгжил- төв мэдрэлийн систем уураг тархи бүтэц, үйл ажиллагааны боловсролт, тархины хэлэхүйн төвийн үйл ажиллагаа, үүнээс гадна нийгмийн нөхцөл- үе тэнгийн насанд хүрэгчдийн харилцаа, түүний ойролцоох хэл ярианы даган дуурайх загвар болсон эхийн харилцаа чухал.



- 
- Хэл яриа хөгжихөд шинэ үйл ажиллагаа харилцааны шинэ хэлбэр нөлөөлөх ба энэ насанд эд юмстай хийх үйлдлийн харилцаа.
  - Бага насны хүүхдийн хэл ярианы хөгжил төлөвшил нь үйл ажиллагааны шинэ төрлийн хөгжил, насанд хүрэгчидтэй харилцах харилцааны шинэ хэлбэртэй тус тус холбоотой.
  - Үйл ажиллагааны болон харилцааны шинэ хэрэгцээ нь хүүхдийн хэл яриа, түүний үгийн нөөц, дүрмийн бүтцийг эзэмшихэд нь идэвхжүүлж өгдөг. Энэ бүгдийн үр дүнд нь хэл яриа улам боловсрогуй болохын хирээр хүүхдийн хэл яриа нь түүнд нийгмийн туршлагыг дамжуулах, насанд хүрэгчдийн зүгээс түүний үйл ажиллагааг удирдах чухал хэрэгсэл болж хувирдаг.

- 
- Сэтгэцийн хөгжил, төлөвшил нь хэл ярианы үйл ажиллагаа болон хэлний чадвартай маш нарийн холбоотой байдаг.
  - Хүүхдийн хэл ярианы идэвхтэй байдал нэмэгдэхэд түүний сэтгэцийн үйл ажиллагаа дээшилдэг. Хүүхдийн сэтгэцийн бүхий л үйл ажиллагаа түүний хэл яриагаар дамжин хөгждө
  - Хэл яриаг эзэмшснээр хүртэхүй, сэтгэхүй, ой тогтоолт өөрчлөгдөж хүүхдийн үйл ажиллагааны бүх л хэлбэр нийгэмшил тэр дундаа бусад хүүхэд, хүрээлэн буй насанд хүрэгчидтэй харилцах харилцаа мөн адил боловсронгуй болж байдаг.




- 
- Эсрэгээр нь хэл яриа эзэмших процесс нь хүүхдийн үйл ажиллагаа, хүртэхүй, сэтгэхүйн хөгжлийн бүх хэлбэрээс шалтгаалж байдаг.
  - Сайн хөгжсөн хэл яриа нь түүний сэтгэцийн хөгжлийн хэвийн байдлыг илтгэдэг бөгөөд үе тэнгийнхэн болон бусадтай харилцах харилцааны үндэс болдог.
  - Хэл яриа нь үеийн тэнгийхэнтэйгээ болон насанд хүрэгчидтэй харилцах харилцааны явцад хөгждөг.

## Хэл ярианы хөгжлийн өмнөх үе

- Хэл яриа эзэмших өмнөх бэлтгэл үе, Е.Н. Винарская:
- Нярай хүүхдийн уйлах, хашгирах үе ( 0- 2-3 сар )
- Ганганах үе ( 2-3 сараас– 5-6 сар )
- Эрт үеийн үгийн хөгжил ( 5-6 сараас– 9-10 сар )
- Үг хэлэхийн өмнөх үе ( 9-10 сараас – 12-14 сар )
- Дууны өнгө бүхий үгийн хөгжлийн хожуу үе (12-14 сараас– 18-20 сар)

# Хэл ярианы хөгжихөөс өмнөх болон хэл ярианы хөгжлийн үе


- Энэ үе шатанд үгийг бүтээж байгаа авиа бүрийг сонсож, хүртэн хүлээн авах нарийн төвөгтэй үйл ажиллагаа үе шаттай явагддаг. Хүүхдийн уйлах, ганганах гунганах явцад өгүүлэх эрхтний хөдөлгөөн, идэвх нь хөгжиж сайжирдаг. Насанд хүрэгчдийн зүгээс үзүүлэх дуу хоолойг сонсноор түүний ойлгох чадвар хөгждөг.
- Эрдэмтэн судлаачид нярай болон балчир насны хүүхдийн хэл ярианы өмнөх болон хэл ярианы хөгжлийн байдлыг дараах үндсэн гурван хүрээний харилцан холбоо хамаарал, харилцан бие биеэ нөхцөлдүүлж байдлаар авч үзэж дүн шинжилдэг.
- **Дуу хоолойн (дуулалт, уран сайхны тал) илрэл**
- **Сэтгэц хөдөлгөөний хариу үйлдэл**
- **Бие даасан харилцааны хэсэг**
- Хэл яриа бол сэтгэц физиологийн ерөнхий хөгжлийн элемент юм.
- Хүүхдийн уйлах нь түүний сэтгэц физиологийн маш баялаг бүтцийг илтгэж байдаг. Хүүхэд, хандсан яриаг ойлгох гэдэгт авиаг ялгах энэ үндсэн дээрээ эх хэлнийхээ үг, өгүүлбэр хүрээлэн буй хүмүүсийн ярьж буй ойлгох зэргийг багтаадаг.


- 
- Хүний хэл яриа 2 үндсэн үйл ажиллагаанд хуваагддаг. Үүнд:
    1. *Экспрессив*: үгэн дохиоллыг боловсруулах, бүтээх - *аман яриа, ярих*
    2. *Импрессив*: үгэн мэдээллийг ойлгох - *хэл яриаг хүлээн авах, ойлгох*

Энэ 2 үйл ажиллагаа илрэх байдлаараа хоорондоо маш нарийн холбоотой, гэхдээ мөн чанарын хувьд маш их ялгаатай.


Аман яриа боловсрогдон явагдагдахад өгүүлэх эрхтний хөдөлгөөнд (хэл яриа хөдөлгөөний анализатор) идэвхтэй байдал хамгийн их явагддаг,

Хэл яриаг хүлээн авах явцад сонсголын эрхтний хүлээн авуурын хүртэхүй (хэл яриа сонсголын анализатор) идэвхждэг.

- 
- Хэл ярианы авиаг ялгах чадварын хөгжил хүртэж мэдрэхүйн ерөнхий зарчмаар явагддаг. Хүртэж мэдрэхүйн ерөнхий зарчим: эхлээд нилээд том, мэдэгдэм шинж тэмдгийг, аажмаар бага, үл анзаарагдам шинж тэмдэг, хэсгүүдийг ялгаж сурч эхэлдэг. *В.И.Бельтюков*
  - Хүүхэд эхлээд хэл ярианы урсгал доторх бүтэн үе, үеийн багц (нэг үг мэт хүлээн авагдаж буй), нүүрний хувирал, дууны өнгө нь гэх мэт тодорхой хавсарсан хэл яриаг хүлээн авч эхэлдэг.


- 
- Энэ нөхцөлд үгийг 12-13 сартайд ялгаж эхлээд 2,5 насандаа бүх авиаг ялгаж чадна.
  - Хүний яриаг ялган хүртэх хугацаа янз бүр, үгийн цаана утгыг ойлгоно, өөрийнхөө түвшинд утгачлах ба ийм чадвар 1 нас гэхэд илэрнэ, түүнд хандсан яриаг ойлгоно, хэдийгээр үг мэдэхгүй ч өөрт үүссэн сэтгэгдлээ илэрхийлэх гэж оролдоно. Харилцааны хэрэгсэл дотор дохио зангаа, нүүрний хувирал, харц орно хүүхдэд үг л дутагч байдаг, өөрийн гэсэн үг үүсэх нь хүүхдийн хэл яриа, танин мэдэхүй, харилцааны хөгжилд том үсрэлт болдог.




- 
- Энэ үед 50-70 идэвхгүй үгийн нөөцтэй байдаг. Идэвхгүй үгийн нөөцөөс ипэвхтэй үгийн нөөцөнд шилжихэд идэвхжүүлэлт өдөөлт чухал.
  - Эцэг эхийн хувьд хүүхдийн анхны үг ямар үг байв? Энэхүү анхны үг бий болоход юу нөлөөлөв гэдэг асуулт чухал байдаг
  - Нэг нас хүрэхэд хүүхдэд хүрээлэн буй орчинтойгоо харилцахад хангалттай хэмжээний тогтолцоо буй болж хөгжсөн байдаг.
  - Хүүхэд, энэ үед хандсан хэл яриаг ойлгох боломжтой болсон, дуу хоолойн илэрхийллийн хүрээ төлөвшсөн байна, Харилцааны хэрэгсэл дотор нүүрний хувирал, дохио зангаа, биеэр үзүүлэх байдал байдаг.


## Үгэн харилцааны үйлдэл бүрийг үргэлж

- хэл яриаг хүлээн авах (сонсох),
- хэл яриаг бүтээх (ярих) гэсэн хоёр хүрээнд авч үздэг.
- Гэхдээ сонсох нь ярихын үйлийн өмнө явдаг. Хэл яриаг хүртэн хүлээн авах нь нэг төрлийн үйл явц бус, генетикийн болон үйл ажиллагааны үүднээс авч үзвэл энд *ялгах, таних* гэсэн түвшин явагдаж байдаг
- Хэл ярианы дохиолол боловсруулах үйл явцыг авч үзвэл *сонорын, хүртэн хүлээн авах, утгын* түвшин гэж хуваадаг.
- Аман ярианы сонорын хүртэхүйг *1. дуудлагын анализ буюу үгэн дэхь авиаг ялгах, 2. хүртэн хүлээн авах түвшинд сонссон авиагаа таних 3. өгүүлбэрийн утга өгүүлж буй зүйлийн агуулгыг бүхэлд нь ойлгох,*
- Хүүхдийн дуудлага болон хөдөлгөөний хүртэхүй далд явагдаж байдаг


- 
- Ярих үйл явцын үндсэн салбар бол авиа болон үгийг дуудахад шаардлагатай өгүүлэх эрхтний хөдөлгөөн, байрлал бөгөөд энэ нь сонголын анализатортын хүртэн мэдрэхүйтэй харилцан нийлдэг.
  - Хэл яриаг хүртэн хүлээн авах үйлийн үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь *авиаг ялгах чадвар* юм.
  - Хүүхэд өөрт нь хандсан насанд хүрэгчдийн үгэн дундаас өөрт нь дуудахад хүртээмжтэй авиануудаас л сонгож авдаг ч энэ нь үг дуудахад бэлэн гэсэн үг биш бөгөөд харин хялбар үг, дуудлагад тааламжтай ханддаг.
  - Өгүүлэх эрхтний хөдөлгөөний тэнцвэрт байдлын дутуу хөгжил нь үгийн бүтэц дэхь авиа тус бүрийг зөв дуудаж дамжуулахад саад болж хүүхэд буруу дуудах байдал бий болдог.
  - Ингэснээр хүүхэд үгийн авиа тус бүрийг зөв дуудах бус харин үгээр өгч буй материалын дууны өнгө, чанга сул, хэмнэл тал уруу илүү шилжиж


- Анхны үг - янз бүрийн авиаг давтан хэлж буй цуврал авианууд эсвэл анхны энгийн үгнүүд байдаг : *аав, ээж, ля-ля, ав - ав, ко- ко бай- бай, гэх мэт.*
- Үүний зэрэгцээ хүүхдэд өөрт нь ойлгомжтой үгийг дүрслэн хэлэх шинжтэй мөн үгийн авиаг давтан хэлэх байдал давамгайлж эхэлнэ. *би – би (машин), ав - ав (нохой), ко - ко (тахиа)*
- Авиаг давтан хэлж буй цуврал нь хүүхдийн хэл яриа үе үгийг даган дуурайхаас өөрийн үгэн хэл ярианд шилжих үе.
- Авиан цувралуудыг “цуурай” хэлбэрээр давтах байдал түгээмэл


- 
- Хүүхдийн хэлж буй анхны үгнүүд нь - хэлний авиануудыг санамсаргүй байдлаар давтан хэлэх, холбож хэрэглэхээс эхлээд зорилго чиглэлтэйгээр амьсгалын эртхэн, дуу авиа үүсгэх эрхтэн, өгүүлэх эрхтний хөдөлгөөнийг хэрэглэхэд шилжих шилжилт юм.
  - Анхлан ярьж буй хүүхдийн хувьд үгийн дуулалт сонсголт чанар болон бүтэц нь авиан дуудлагын бүтцээс илүү чухал ач холбогдолтой.
  - Хүүхэд хэдийгээр үгийн авиануудыг ялгаж сураагүй байдаг ч үгийг дуудлага сонсголт талаас нь харьцангуй зөв хийдэг.

- 
- Хүүхдэд анхны үг үүсэх хугацаа янз бүр байна. Нэг хэсэг нь 9 сараас, нөгөө нэг хэсэг нь 1 нас, зарим нэг нь 2 нас болон бүр хожуу ч хэлд орно. Хүүхэд бүрт үгийн нөөц мөн харилцан адилгүй байна, 1 насанд 2-3 үгнээс 15-20 үг, энгийн үг 5-10 үгтэй, даган дуурайж давтан хэлсэн үг олон байх ба харин 2-3 насанд үгийн нөөц нэмэгддэг.
  - Хүүхдийн хөгжлийн эхэн үед үгийн нөөц эрчимтэй нэмэгдэхийн зэрэгцээ эх хэлнийхээ дүрмийн тал, хэм хэмжээг эзэмшиж эхэлдэг.
  - Үгийн санд хоёр бүрэлдэхүүн хэсгийг ялган үздэг: *Тоон, чанарын*
  - Чанарын тал нь хэлний дотогшоо чиглэсэн, хүүхдийн хэрэглэж буй үгийн утгат байдал. Хүүхдийн хэрэглэж буй үг өөрийн гэсэн утга санаа, тэмдэгттэй,



- 
- Хүүхдийн хэл яриа, нийгмшлийн чадвар нэмэгдэхийн хирээр үг нь анх хэрэглэж байснаас илүү зөв утга агуулгатай, хэрэглээтэй болж ирдэг, хүүхдийн хувьд үг, эд юмсыг тэмдэглэсэн тэмдэглэгээ
  - Хүүхэд үгийг эзэмшснээр түүний гурван шинжийг бүхэлд нь нэгэн зэрэг эзэмшиж эхэлдэг. Үгийн: *Авиан дуудлага тал, Эд юмсын шинжтэй, Утга агуулсан харьцуулалт*. Хүүхэд 1,8 насанд идэвхтэй үгийн нөөц сард 8 үгээр нэмэгдэх ба 1,9 насанд хэл ярианы тэсрэлт явагдана. Үгэнд дүгнэлт хийж, ойлголт нэмэгдэнэ, үг болон эд юмсын хооронд харьцуулалт явагдана. Холбоо үг бий болно, утга төгс шинжтэй, ингэснээр танин мэдэх үйл ажиллагаанд хөгжил гарч шинэ шинэ утга шаардсан үг үйл явдал бүхий материалыг шаарддаг.

- 
- Хүүхдийн танин мэдэхүйн хүрээний хөгжил нь бүхий л шинэ зүйл, шинэ үгийн сан, шинэ агуулгыг шаарддаг,
  - Эсрэгээрээ хүүхдийн үгийн нөөц нэмэгдэх, системтэй болох нь үгийн бүтэц холбох дэс дараалал дээр өөрөөр хэлбэл холбоо үг, өгүүлбэрийн үндсэн дээр явагддаг. Авианаас үе, үенээс үг, үгнээс өгүүлбэр, өгүүлбэрээс эх үүсч бий болох тухай,
  - Дүрмийн хувьд зөв өгүүлбэр бүтээх нь үгийн нөөц нэмэгдэх, насанд хүрэгчдийн хэл ярианы загварыг давтан хэлэх хүслээс илүү хүрээлэн буй хүмүүсийн хэл ярианаас хэлний утгат нэгжийг бие даан нэгтгэн дүгнэж чадаж буй байдлаас хамаарна.

- 
- Дүрмийн хувьд алдаатай үг өгүүлбэр хэлэх нь удаан биш 2,5 сар орчим үргэлжилдэг, үг холбож өгүүлбэр үүсгэх техникийг аажмаар ойлгоно, нэр үг, үйл үг хэрэглэнэ, тийн ялгалын дагавар ялгаж эхэлнэ. *Аав ирсэн. Аав илсэн. Хүүд өгөөрэй. Хүү өгөөрэй. Мууранд өгөөрэй. Муур өгөөрэй.*
  - Хүүхдийн хэл ярианы чухал хэсэг бол үгсийн санг бие дааж утгын болон дүрмийн хувьд зөв холбож хэрэглэх чадвар үүсч бий болох үе 3 наснаас өмнө бий болж хөгждөг.

# Хүүхдийн хэл ярианы хөгжихөөс өмнөх үеийн үзүүлэлт

## □ Төрснөөс хойш нэг сар хүртэлх

- Хүүхдийн хөгжлийн эхний сар дээр төрөлхийн үндсэн рефлекс болох бүх биеийн, дээд, доод мөчдийн хөдөлгөөн, мөн дуу хоолойн уйлах орилох, шинэ өвөрмөц зүйлд хараа тогтох гэх мэт нь илүү тод илэрдэг.
- Дуу хоолойн хариу үйлдэл - дөнгөж төрсөн нярайн гаргаж буй авианууд ба түүнийг хүүхдийн амьдралын чухал физиологийн үйл ажиллагаа болох (хашгарах, уйлах, ханиах, найтаах, эхээ хөхөө явцад гарч буй дуу авиа, эвшээх) -аас салгаж болохгүй.
- Үйлах нь хэвийн үед чанга, цэвэр, дунд эсвэл доогуур дууны өнгөтэй, амьсгалаа богино авч уртаар ойролцоогоор 1-2 секундэд амьсгалаа гаргах байдалтайгаар (*ya- a- a*), дуу хоолойн өнгөний илэрхийлэлгүйгээр гаргана.
- Хүүхэд тагнайн, тодорхой *а ба э* гэх мэт дундын авиаг гаргадаг.

# 1-ээс 3 сар хүртэл

- Энэ үед хүүхдийн төрөлхийн үндсэн рефлекс өргөжиж эхэлнэ.
- Уйлах нь дуу хоолойн өнгийг олж эхлэх ба ганганах, инээх гэх мэт агуулгыг тусгадаг
- 3 сар гэхэд уйлах нь сөрөг сэтгэлийн хөдөлгөөнийг илэрхийлж эхэлдэг, юунаас болж уйлж байгаагаас шалтгаалан янз бүрийн шинжтэй болно. Сайн ээж, хүүхдийнхээ уйлж буй шинжээр нь түүний биеийн байдлыг тодорхойлдог. Хүүхдийн уйлах байдал өвчин, өлсгөлөн, нойтон байдлаас үүссэн таагүй мэдрэмж зэргээс шалтгаалан янз бүр байдаг.
- Аажмаар уйлах давтамж багасч, анхдагч ганганах байдал эхэлнэ. (Янз бүрийн эгшиг авиаг тагнайн гийгүүлэгч авиануудыг **З,К,Х** давтан хэлнэ.) Энэ үед анхны инээд бий болно. Тэр хэмжээгээр харилцааны идэвх нэмэгддэг.

## 3 -аас 6 сар хүртэл

- Энэ үед хэвийн хөгжилтэй хүүхдэд жинхэнэ дуулалтай ганганах янз бүрийн гийгүүлэгч болон тагнайн авиануудын хосолсон, урт үргэлжилсэн, дуу хоолойн өнгөтэй эгшиглэлт байдал эхэлнэ.
- Өмнөх үеэс ялгаатай нь эгшиг авиа, тагнайн авиа илүү хосолмол байдалтай болно, ганганах үйл нь хүүхдийн амьсгалаа гаргах явцад илүү ажиглагддаг. Хэлний дуу хоолойн өнгө талын хөгжил явагдах суурь бий болж аажмаар эрчимтэй хөгжил явагддаг.
- Цэвэр рефлексийн шинжтэй авиан дуудлагаас нийгмийн шинжтэй дуудлагад шилжинэ. Ганганах нь харилцааны хэрэгсэл болно, хүн харах, ирэх, харилцах үед илүү хариу үйлдэл үзүүлдэг.
- Ганганах авиануудын хослол аажим баялаг болж ирдэг, авиануудын цуврал урт удаан болж ирнэ, уруулын гийгүүлэгчүүд эгшиг авиануудтай **(па, ба, ма)** нийлж дуудагдаж эхэлнэ.



## 6-аас 10 сар хүртэл

- 6 сар гэхэд хүүхэд эгшиг болон гийгүүлэгч авиануудын (*ба –а- а*), хэлний болон эгшиг авиан хослолыг (*та - а- а, да - а- а*) хэлж эхэлдэг,
- Цуврал авиа дуудах үед тодорхой нэг өгүүлэх эрхтний байрлал шугаман дэс дараалалд ордог.
- Хүүхэд эхлээд авиаг, өөрөө өөрийгөө даган дуурайж (*аутоэхолалия*) давтан хэлэх байдлаар, арай хожуу үед, насанд хүрэгчдийн авиаг даган дуурайж (*эхолалия*) эхэлдэг. Энэ үед голлон *ба-ба, ма-ма, да-да гэж* хэлнэ.
- 6-7 сараас авиаг дуудах нь нийгмийн шинжтэй болж ирдэг. Хүүхэд насанд хүрэгчидтэй харилцах үед илүү авиануудаа дуудаж эхэлдэг.
- Авиа дуудах, гаргах байдлаар бусдын анхаарлыг өөртөө татах оролдлого хийнэ.

## 9- өөс 12 сар хүртэл

- Хүүхдийн авиаг дуудах идэвхтэй үе: авиан нийлэмжид дөрөв тав ба түүнээс дээш үе тоологдож эхэлдэг.
- Авиа дуудах чадвар нь “цэцэглэж ирдэг” ба шинэ авиануудаар, шинэ дууны өнгөөр баяжигдана, насанд хүрэгчид хүүхэдтэй дуу хоолойгоор харилцахад түүнд байнга хариу үйлдэл үзүүлнэ.
- Хүүхэд үеийг давтана, дууны өнгийг сайн даган дуурайна, үгийн дуудлалт байдал нэмэгдэнэ, мэндчилгээг сэргээн давтана.
- Хүүхэд үеийг давтан хэлнэ, сэтгэлийн хөдөлгөөний өнгө илэрнэ.
- Хүүхдүүд янз бүрийн хэлбэрийн *гийгүүлэгч - эгшиг, гийгүүлэгч -эгшиг - гийгүүлэгч* үеийг давтдаг.
- Биологийн хэрэгцээгээ, сэтгэл ханамж, тааламжгүй байдлаа мөн өөрийн гуйлт хүсэлтээ биеийн хөдөлгөөн, дууны өнгө, сэтгэлийн хөдөлгөөнөөр илэрхийлнэ.

# Хэл ярианы эрт үеийн хөгжлийн үзүүлэлтүүд (1-3)

1 1,6

- Хүүхдийн гадагшаа чиглэсэн үгийн нөөц маш хурдан нэмэгддэг.
- Хүүхэд ойр дотны хүмүүсээ ялгана, маш олон эд юмс, үйлдэл, тоглоомын нэрийг ойлгоно, энгийн хэл ярианы зааварчилгааг, өмнө сурсан үйлдлээ биелүүлж гүйцэтгэнэ.
- Идэвхтэй үгийн нөөц ойролцоогоор байнга нэмэгдэж 30-40 үгэнд хүрнэ, эдгээр үгийн дунд маш олон богино үг байна. (*ма-ма, па-па, ба-ба, ля-ля, ам-ам, би - би*)
- Хүүхэд энгийн өгүүлбэрээр харьцана, Үгийг нүүрний хувирал, дуу өнгө, дуу хоолойн дохиогоор нэмж баяжуулдаг.

# 1,6 сараас 3 нас хүртэл

- Хүүхэд насанд хүрэгчдийн яриаг тодорхой нөхцөл шаардахгүйгээр ойлгож эхэлдэг.
- Тэрээр өөрийн хувийн туршлага, үйл явдлын талаар бүтэн өгүүлбэрээр утга ойлгомжтойгоор ярина.
- 2 насандаа зурагт тайлбаргүй том биш өгүүллийг ойлгох чадвартай болсон байна.
- Үйл ажиллагааг үгээр удирдана.
- Хүүхэд эрчимтэйгээр идэвхтэй үгийн баялагийг эзэмшдэг. Хэрэглэж байгаа идэвхтэй үгийн баялаг хоёр насны сүүл гэхэд 300-400 үг болтлоо нэмэгддэг.
- Богино үгийн оронд бүх нийтээр хэрэглэдэг үгнүүд ярианд нь орж ирнэ.
- Хүүхэд ихэнхдээ насанд хүрэгчдийн үг холбоо үгийг давтдаг.
- Хүүхэд харилцахдаа энгийн үг хэллэг ашиглаж эхэлдэг.

## 2 наснаас 2 нас 6 сар

- Хүүхдийн хандсан яриаг ойлгох чадвар эрчимтэй хөгждэг.
- Хүүхэдтэй тухайн цаг үед болж буй үйл явдлын талаар хүүхэдтэй төдийгүй өнгөрсөн болон ирээдүйд болох үйл явдлын талаар ярилцаж болно.
- Энэ үйл явдлуудын илэрхийлсэн өгүүлбэрийн утгыг ойлгоно.
- Эд юмсын гол шинж чанарыг нэгтгэн дүгнэх чадвар амжилттай хөгжинө
- Хүүхэд шинэ үгнүүд, холбоо үг, өгүүлбэрийг хялбархан давтан хэлж эзэмшинэ.
- Хэл ярианд голлон *яагаад ?*, *хаана?*, *хэзээ ?* гэсэн асуултууд бий болно.
- Өгүүлбэр дэхь үгийн тоо нэмэгдэнэ гэхдээ урт нийлмэл өгүүлбэр дүрмийн хувьд алдаатай байна.

## 2 нас 6 сараас 3 нас

- Насанд хүрэгчдийн, хүүхдийн өөрийнх нь туулаагүй гэхдээ зарим нэг тодорхой хэсгүүд өмнө нь шууд хүлээн авч байсан үйл явдал, үзэгдлийн талаарх яриаг ойлгох чадвар хөгжинө.
- Идэвхитэй үгийн нөөц хэлний угтвар нөхцөлөөс бусад бүх хэсэгт орж эхлэнэ.
- Үгийн нөөц маш эрчимтэйгээр баялаг болох бөгөөд гурван насны сүүл гэхэд 1200- 1300 үгтэй болно,
- Хүүхэд хүнд үг, хэллэгээр, хавсарсан нийлмэл өгүүлбэрээр заримдаа дүрмийн хувьд алдаатай ярина,.
- Насанд хүрэгчдийн асуултад хүүхэд, үзснээ хэд хэдэн өгүүлбэрээр ярьж болно.





# Хэл ярианы хөгжлийн саатал

- Нилээд хожуу үед хэл яриа үүсч бий болох эсвэл хэл яриа төлөвших чанар, хурд удаашрахыг хэлнэ.
- Идэвхтэй үгийн нөөц удаан нэмэгдэх, хэллэг, холбоо үг хожуу үед бий болох, хэлний дүрмийг хүндрэлтэй эзэмших